

Казанский федеральный университет
Институт международных отношений
Институт восточных рукописей
Российской академии наук

Kazan Federal University
Institute of International Relations
Russian Academy of Sciences
Institute of Oriental Manuscripts

*Посвящается 185-летию создания
кафедры монгольской словесности в Казани*



Казанский федеральный
УНИВЕРСИТЕТ
ИНСТИТУТ
международных
отношений



МЕЖДУНАРОДНАЯ НАУЧНАЯ КОНФЕРЕНЦИЯ
Первые Ковалевские чтения

24-26 сентября 2018 г.
г. Казань

**ПРОГРАММА
ТЕЗИСЫ**

Казань – Санкт-Петербург
2018

DOI 10.25882/pqk0-kb52

**«Монголын нууц товчоон» дахь аман уламжлалын зүйл
авантекстийг дохиолох нь. (Намеки авантекста в устных
традициях «Тайной истории монголов»)**

«Монголын нууц товчоон»-ы аман уламжлал юу байв гэдэг асуултанд хариулахыг хичээж олон жил болов. Бидэнд мэдэгдэж буй «Монголын нууц товчоон»-ы уг эх, бичвэр ер нь хаанаас юунаас бий болов гэдгийг эргэцүүлэн бодсоор энэхүү илтгэлийг хэлэлцүүлэгч миний бие 1999 онд «Аман уламжлал ба Монголын Нууц Товчоон» хэмээх эрдмийн ажлыг бичсэн. Уг ажилд МНТ-ы өмнөх уламжлал гэдэгт монголчуудын *домог-үлгэр, баатарлаг тууль, аман түүх* гэх гурван уламжлалыг тодруулан онцлон авч үзсэн юм.

Тухайн үед миний бие «Монголын нууц товчоон»-ы өвөрмөц шинжийн тухайд: “Номын шарласан хуудаснаас, галиг үсгийн давхар бүрхүүлийн цаанаас ч “тал нутгийн үнэрийг” үнэрлүүлэн таниулаад байдаг чанар нь чухам юунд оршиж байна вэ? Чухам үүнд л хариулахыг бид хичээх болно”(Г. Билгүүдэй. Аман уламжлал ба «Монголын нууц товчоон». УБ., 2000. 29 дүгээр тал) гэж бичиж байсан маань чухамдаа «Монголын нууц товчоон»-ы дотроос өмнөх үеийн аман уламжлалын зүйлсийн эрэл хайгуул байсан юм. Энд дурдан буй “өмнөх үеийн аман уламжлалын зүйлс” гэсэн баахан эв хавгүй нуршуу санааг өрнөдийн аман зохиол судлалд авантекст гэх нэр томъёогоор тэмдэглэдэг байна.

Авантекст (фр. *l'avant-texte* »дотекст, прототекст//эхийн өмнөх, өвөг эх») гэх нэр томъёог өнгөцхөн харвал цэрэг дайны урлагт хэрэглэгддэг авангард (фр. *avant-garde*, «*avant*» — /өмнөх/; «*garde*» — /харуул/) гэх үгтэй төстэй, тийм л аргаар үүссэн үг гэлтэй. Иймээс *авангард* гэдгийг монгол цэргийн ухаанд *толгойн сэргийлэх анги /харуул/* гэх мэтээр орчуулан ярьдаг.

«Монголын нууц товчоон»-ы 37 дугаар зүйлд “Гэр-тур-ийан хүрээд ах-а нар, дэгү нар хэлэлдэж морилаба. Мөн Бодончар-и алгинчи хагулгаба” гэж гарч байгаа нь ах дүү нар хэлэлцэж тохиролцоод дорой иргэнд морилохдоо дүү Боданчарыг “*алгинчи хуулгав*” гэсэн нь авангард болгон довтолгов гэсэн үг болно.

Иймээс энэ авантекст гэх үгийн “аван” гэх утварыг *өмнөх* юм уу эсвэл *өвөг*, “текст” гэх төгсгөл хэсгийг эх юм уу эсвэл *бичвэр* гэж орчуулбал дээрх нэр томъёо нь “*өмнөх эх - өмнөх бичвэр*”, “*түрүү эх – түрүү бичвэр*”, “*өвөг эх – өвөг бичвэр*” “*түрүүч эх – түрүүч бичвэр*” гэх мэтээр хөрвүүлэн авч болох ч эд бүгд үгчилсэн махчилсан болхи толхи орчуулга төдий л зүйл болно. Гэтэл энэ авантекст гэх нэр томъёог 1972 онд францын эрдэмтэн Ж.Белмен-Ноэл гэгч “генетикийн шүүмжлэл”-д анх авч хэрэглэсэн ажээ. Францын “генетикийн шүүмжлэл”-д уг нэр томъёог дараах байдлаар тодорхойлж байна.

“Авантекст” гэх нэр томъёо нь “генетикийн шүүмжлэл”-д бүрэн гүйцэд бичиж дууссан бүтээл гарахын өмнөх хэрэглэгдэхүүний бүхий л цогсосыг тэмдэглэдэг нэр байжээ. Энэ нь тухайн бүтээл төрөхөд хүргэсэн олон янзын хувилбар, хар цагаан ноорог, зураглал, төлөвлөгөө гээд тухайн зохиол бүтээлийн “генетик баримтын хавтас” мэт зүйл гэж ойлгодог байна. Аль эсвэл тухайн бүтээлийн утга бүрэлдсэн үйл явцыг илрүүлэн гаргахад тухайн досье буюу баримтын цуглуулгаас шүүн гаргаж ирсэн оюун дүгнэлтийн байгууламжийг хэлдэг байжээ. Авантекстийн үзэл баримтлалын талаар: Ж.-Б.Ноэль. Воссоздать рукопись, описать черновики, составить авантекст // Генетическая критика во Франции. Антология. Отв. ред. А.Д. Михайлов. Вст. ст. и словарь Е.Е. Дмитриевой. М., 1999, с. 98-114. гэдэг номноос үзнэ үү.

Өрнө дахинд саяхнаас хэрэглэгдэх болсон авантекст гэх нэр томъёоны тодорхойлтыг санагдуулам зүйлийг дорно дахинд аль эрт цагт, дээр үеэс, үүнийг өчүүхэн тодруулбал эртний Энэтхэгийн Дандины зохиолд тохиолдож байна.

Энэ нь дорно дахины, тухайлбал, эртний Энэтхэгийн туурвил зүйн онолч Дандины «Зохист аялгууны толь»-ийн утгын 35 чимгийн сүүлийн буюу 35 дахь чимэг болох “Таалалт чимэг” хэмээхийн доторхи “Зохист аялгуучны сэтгэснийг **таалал** хэмээн хэлмүй” гэдэгтэй ихээхэн ижилхэн санаа болно. «Зохист аялгууны толь»-ийн Таалалт чимэгийн тодорхойлт болон түүний тайлбарыг үзвэл:

«Таалалтын чимэг (ca: bhavikam, тө: dgons pa can gyi rgyan) нь зохист аялгуучин анх зохиол бүтээл туурвиж эхэлснээс бүрэн төгсөх хүртэл юу өгүүлэхээр сэдэж санаж хадгалж бодсон тэр бодлын илэрцийг “Таалалтын чимэг” хэмээн нэрлэжээ. Дандин:

Энд *таалал*, *таалалт* хэмээх хоёр ойлголт байна. Зохист аялгуучин тэрбээр өгүүлэгдэхүүн түүнийг өгүүлэх ёс, зохист

аялгууны чимэг аль байдлаар өгүүлэхийг хүссэн бодол буюу санааны үргэлжлэл түүнийг “*таалал*” хэмээж байна. Өөрөөр хэлбэл, таалал хэмээхийг нь бодол, санаа, онгод, хөглөл, төлөвлөгөө ч гэж хэлж болно».

Одоо бид авантекст, текст, таалал, таалалтыг гэрчлэн харуулах зарим нэг жишээ баримтыг гаргаж ярья.

«Монголын нууц товчоон»-ы эх дотор авантекст-ийн дохио тэмдэг болсон зарим нэг зүйл байна. Жишээлбэл, «Монголын нууц товчоон»-ы 52, 57 дугаар зүйлд монголчууд хаанаа хэрхэн сонгон өргөмжилдөг байсныг өгүүлсэн хоёр хэсэг байна. Энэ бол «Монголын нууц товчоон»-ы эхэд орсон таалалтын буюу текстийн жишээ. Энд монголчууд хаан болох хүнээ хэлэлцэж, өмнөх хааны гэрээс захиасын дагуу сонгон өргөмжилдөг тухай өгүүлжээ. Ийм цуглаан дээр хүмүүс юу ярьж хэлэлцэснийг «Монголын нууц товчоон»-д дэлгэрэнгүй бичсэнгүй. Өөрөөр хэлбэл таалал буюу авантекст нь мэдэгдэхгүй байна гэсэн үг.

Хамаг монголыг эхлээд Хабул, дараа нь Амбагай мэдэн байсан, эцэст нь Амбагай хааны Хадаан, Хотала хоёрыг нэрийдэж илгээснээр хамаг монгол тайчууд Ононы Хорхоног жубурт хурж Хоталыг хаан болгов гэсэн нь хэн хэн монголын хаан болов гэдэг сонгуулийн үр дүнг мэдээлжээ. Харин монголчууд хурж хаанаа сонгохдоо хэрхэн хэлэлцэж чухам юу гэж ярьдаг хэлэлцдэг байсныг гэрчлэх баримт буюу тааллын буюу авантекстийг бид Рашид-ад-Дины номоос мэдэж болж байна.

Харин Рашид-ад-Дины «Судрын чуулган»-д Тайчиуд нь дотроо эв нэгдэлгүй байснаас хаанаа сонгож чадахгүй удсан гээд:

Ш. Гаадамба 1961 онд орос хэлээр бичиж эрдмийн зэрэг хамгаалсан «Сокровенное сказание монголов как памятник художественной литературы (XIII в.)» /»Монголын нууц товчоо» бол /XIII зууны/ монголын уран зохиолын дурсгалт бичиг мөн/ хэмээх ажлынхаа гуравдугаар бүлгийг “Нууц товчооны” уламжлалд зориулжээ. «Монголын нууц товчоон»-ы уламжлалыг хадгалсан түүхэн домгууд туульсын өнгө аястай, монголчуудын үндэс угсаагаа ухамсарласан, монголчуудыг эв нэгдэлтэй байлгах санааг халуун дотноор уриалсан, Монголын нэгдсэн улсыг байгуулахад хүчирхэг эзний гагц жолоонд орохын чухлыг ятгасан, овог аймгийн хоорондын самуун дайсагналыг жигшин эсэргүүцсэн байдгаараа нэг чиг урсгалын гэж болох зохиолууд байдаг билээ.

«Тэр үед монгол овог аймгууд эв нэгдэлтэй байх санаа нь хамгийн их дэлгэрсэн гэдгийг энэ бүхэн харуулж байна. Энэ үүднээс Хүдэй буюу эсвэл Матугун сэцний хэлсэн үг онцгой сонирхолтой юм. «Алтан товчийн» Хүдэй-сэчэн болоод Мүтүгүн (аль эсвэл «Судрын чуулганы» доторхи Матугун-сэчэн) хоёр бол нэг хүн гэж Ц. Дамдинсүрэн итгэлтэй хэлж байсан. Гэвч бид Рашид-ад-Дины номоос: “Урнат аймгийн Кукдай, Матугин, Төмөр-Урах мэт ахуй амьдралын асар их туршлагатай өвгөд ятган хэлсээр авч тэдний үгийг ухан ойлгож хүлээн авсангүй.

Сүүлд тэд чухам ямар тогтоол гаргасан гэдгийг бат ноттой мэдэж чадаагүй боловч Есүгэй бахадур залуугаараа нас барсанд тайчуудын олон аймгууд Чингис хааныг эсэргүүцэн босов. Тэдгээр эсэргүүцэгдсийн түрүү нэг нь Адал ханы хөвгүүн Таргутаи Кирилтук, дараа нь Тудай, бас Курил-бахадур, Анку-Хакучу нар болон бусад эрхтнүүдийн тухай [доор] өгүүлэх болно. [Эдгээрийн дотор] хамгийн түрүү дурдагдсан нь Таргутаи-Кирилтук юм. Үүнээс үзэхүүл аймгийн ахлагчийн ор ба эрхийг лав түүнд олгосон байх ёстой. Гэхдээ түүний ач Хотала хаан нас барсны дараа Чингис хааны эцэг, Бартан-бахадурын хөвгүүн Есүгэй-бахадур ноёрхох болсон нь итгэлтэй хэрэг юм. Кабул-ханы Бартан-бахадураас гадна бусад хөвгүүдийн тухай өгүүллэгүүд олон боловч энэхүү ойлбор бичигт [тэд] үүгээр хязгаарлаж, Бартан-бахадурын тухай түүний үр хүүхдийн тухай тусгайлан өгүүлэх болно.

Эндээс бид Матукун сэцэн Тайчуудын хуралд юу хэлснийг тодорхой мэдэж болж байна. Матукун сэцэн Амбагай хааны хөвгүүдээс хэн нь хан ор суух вэ гэдэг дээр “хөл нь урхинд орчих болов уу” хэмээн эмээж байж үгээ хэлсэн нь харагдаж байна. Нөгөө талаар Матукун сэцний үгийг тайчууд аймгийн хоорондоо хагаралтай зонхилогч нар хүлээж авахгүй байсанд сэтгэл нь урамгүй болж хурлаас уйлсаар гарч одсон тухай тодорхой өгүүлжээ.

Үүнээс үзэхэд Хүдэй цэцэн /Хөхдэй – Судрын чуулганд/, Матукун цэцэн хоёр бол тус тусдаа хүмүүс байсан бололтой. Гэвч эдгээр цэцдийн үгийн утга хэлсэн санаа нь хамаг монголчуудыг эв санаа нэгдэлтэй байхыг сануулан хэлсэн утгад зангилагдаж байна. Эдгээр цэцдийн хэлсэн үг бол бидний сонирхон судлаж буй авантекст буюу түрүүч эхийн шилдэг содон жишээ мөн бөгөөд энэ шүлэглэсэн үг ч азаар хожуу үеийн түүхэн зохиол «Алтан товч», монголчуудын аман хууч ярианы цуглуулга гэмээр персийн түүхчийн «Судрын чуулган»-д тэмдэглэгдэн бидний үед уламжилжээ.

Энэ Зочийн хэлсэн үгнээс “эрхийгээ огтолж огорсугай” гэх “таалалт” болох бөгөөд үүний “таалал” нь /барууны ойлголтоор авантест нь/ тэгвэл юу болох вэ гэдэг асуулт тавигдвал тэр нь монголын Эрхий мэргэний домог үлгэрт гарах Эрхий мэргэний андгай тангарагийн үгэндээ хүрч чадаагүйн улмаас “эрхийгээ огтлоод, эр хүнээ байгаад, хар ус уухгүй, хагд өвс идэхгүй, харанхуй нүхэнд амьдарна” (Хүрэлшаа. Монгол домгийн соёл судлал. УБ., 2017.95-р т.) гээд тарвага болж хувирсан гэх домог-үлгэрийн баатрын үгтэй шууд холбогдоно.

Л. В. Будажапова

DOI 10.25882/4zjz-a277

Семантическое освоение буддийских терминов в бурятском языке

Буддийская лексика бурятского языка обнаруживает довольно сложный по происхождению лексический состав, отразивший путь исторического развития буддизма среди бурят. Основной состав религиозно-буддийских слов составляют заимствования из тибетского языка через письменно-монгольский или из санскрита через письменно-монгольский и тибетский: бур. *бадар* ‘подаяние, подношение странствующим монахам’, п.-монг. *badir*, санскр. *pattra* ‘жертвенная чашка’; бур. *диваажан* ‘рай’, п.-монг. *divajinq*, тиб. *bde-ba-can* ‘рай Будды Амитабхи’, бур. *дамаари* ‘ламский барабанчик, бубен’, п.-монг. *damagu*, тиб. *da-ma-gu*, санскр. *damagu* ‘маленький барабанчик’.

Пути проникновения слова сказывались на его семантике, которая претерпевала известные изменения. Большую роль в освоении заимствованной группы выполнял характер заимствования (устный или письменный, непосредственно из языка источника или через язык - посредник). Слова, заимствованные устным путем, легче адаптировались в заимствующем языке; также легко осваивались слова, заимствованные через язык - посредник.

Буддийские термины, проникшие в разные периоды в монгольский письменно-литературный, а затем в бурятский письменно-литературный язык, в период первоначального заимствования имели строго определенное значение, но большая часть из них затем в разное время изменяли свои значения.